



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2019 оны 08 сарын 12 өдөр

Дугаар А/380

Улаанбаатар хот

Гадаад сургалтад суралцуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн сайдын 2014 оны 119 дүгээр тушаалаар баталсан “Эрүүл мэндийн ажилтанг гадаад оронд мэргэжлийн сургалтад хамруулах журам”-ын 1.5 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын “Эрүүл мэндийн ажилтны 2019-2020 оны төгсөлтийн дараахь сургалтын чиглэл, хяналтын тоо, сургалтын хөтөлбөрийн жагсаалт, эмнэл зүйн сургагч багшийн төлөвлөгөө, сургалтын зардал батлах тухай” 2019 оны А/121 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага (ЖАЙКА)-тай хамтран хэрэгжүүлж буй “Монгол Улсын анхан ба хоёр дахь шатлалын эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараахь сургалтыг сайжруулах” төслийн хүрээнд Япон Улсад 2019 оны 11 дүгээр сараас 12 дугаар сард зохион байгуулах “Эмнэл зүйн туршлага судлах сургалт”-д суралцах албан тушаалтан, эмнэлгийн мэргэжилтний нэрийг нэгдүгээр, сургалтын удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Гадаад сургалтад шаардагдах зардлыг холбогдох зардлын зүйл ангиас тооцон гаргахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Д.Ганцэцэг/-д зөвшөөрсүгэй.

3. Сургалтад суралцах хугацаанд тухайн албан тушаалтан, эмнэлгийн мэргэжилтний үүрэгт ажлыг зохицуулж ажиллах, сургалтын удирдамжийн дагуу үр дүнг тооцон ажиллаж, эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараахь сургалтын үйл ажиллагаанд нэвтрүүлэхийг эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга, Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн дарга /Б.Бямбадорж/-д даалгасугай.


САЙД



Д.САРАНГЭРЭЛ

081452

Эрүүл мэндийн сайдын 2019 оны .08.
сарын 12-ны өдрийн 1/380 дугаар
тушаалын 1 дүгээр хавсралт



“Япон Улсад эмнэл зүйн туршлага судлах сургалт”-д
суралцах албан тушаалтан, эмнэлгийн мэргэжилтний нэр

1 дүгээр ээлж: 2019 оны 11 дүгээр сарын 17-ноос 11 дүгээр сарын 30

1. Мягмаржавын Уртнасан, Орхон аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн Хүүхдийн тасгийн эрхлэгч, Эмнэл зүйн сургагч багш
2. Лханаажавын Отгонцэцэг, Орхон аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн Амбулаторийн тасгийн уушигны эмч, Эмнэл зүйн сургагч багш
3. Бальдарын Нансалмаа, Ховд аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн эх барих, эмэгтэйчүүдийн тасгийн эрхлэгч, Эмнэл зүйн сургагч багш
4. Шагдарын Нэргүймаа, Өмнөговь аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн Эрчимт эмчилгээ, яаралтай тусламжийн тасгийн зөвлөх, сургалт хариуцсан мэргэжилтэн, Эмнэл зүйн сургагч багш
5. Лувсандагва Бямбасүрэн, Улсын Нэгдүгээр төв эмнэлгийн Чих хамар хоолойн тасгийн их эмч

2 дугаар ээлж: 2019 оны 12 дугаар сарын 01-нээс 12 дугаар сарын 14

6. Пүрэвийн Баярмаа, Дорнод аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн Хүүхдийн тасгийн эрхлэгч, Эмнэл зүйн сургагч багш
7. Дамбаасүрэнгийн Энх-Амгалан, Өвөрхангай аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн зүрх судасны их эмч, Эмнэл зүйн сургагч багш
8. Энхтайваны Жавхаа, Чингэлтэй дүүргийн сургалтын албаны дарга
9. Халзангийн Чинзориг, Чингэлтэй дүүргийн эмчилгээ эрхэлсэн орлогч дарга, Эмнэл зүйн сургагч багш
10. Ихбаярын Гантулга, Гэмтэл согог судлалын үндэсний төвийн Насанд хүрэгчдийн хавсарсан гэмтлийн тасгийн их эмч

Эрүүл мэндийн сайдын 2019 оны . . . 08
сарын . 12 -ны өдрийн #1380 дугаар
тушаалын 2 дугаар хавсралт

“Япон Улсад эмнэл зүйн туршлага судлах сургалт”-ын удирдамж

Нэг. Оролцох хугацаа, суралцах байгууллага:

- 1 дүгээр ээлж: 2019 оны 11 дүгээр сарын 17-ноос 11 дүгээр сарын 30-ны өдрүүдэд Япон Улсын Токио хот дахь Олон Улсын Эрүүл Мэнд, Нийгэм Хамгааллын Их Сургууль (International University of Health and Welfare, Tokyo, Japan)-д,
- 2 дугаар ээлж: 2019 оны 12 дугаар сарын 01-нээс 12 дугаар сарын 14-ний өдрүүдэд Япон Улсын Токио хот дах Олон Улсын Эрүүл Мэнд, Анагаах Ухааны Үндэсний Төв (National Center for Global Health and Medicine, Tokyo, Japan)-д,

Хоёр. Үйл ажиллагаа:

- Эмнэл зүйн ажиглах сургалтын үйл ажиллагаанд идэвхтэй оролцох,
- Япон Улсын эмнэл зүйн сургалтын үйл ажиллагааны туршлагаас судлах,

Гурав. Үр дүн:

- Сургалтын тайланг бичиж, байгууллагын удирдлагад танилцуулах, сургалтын тайланг Эрүүл мэндийн хөгжлийн төвд хүргүүлэх
- Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтын үйл ажиллагаанд Япон Улсын эмнэл зүйн сургалтын туршлагаас нэвтрүүлэх, нутагшуулах чиглэлээр Эрүүл мэндийн хөгжлийн төвтэй хамтран ажиллах
- Дорнод, Өвөрхангай, Өмнөговь, Ховд аймгийн Бүсийн Оношилгоо, Эмчилгээний Төвийн тухайд “Ерөнхий мэргэшил судлал” үндсэн мэргэшлийн сургалт явуулах бэлтгэлийг хангахад идэвхтэй оролцох, Эрүүл мэндийн хөгжлийн төвтэй хамтран ажиллах